

ХАЛДВАР ТАРХАХ ҮЙЛ ЯВЦ: НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН БОЛОН СОЦИАЛЬ ҮНДЭС

“2012.12.21”- ны жишээн дээр

Д.Баасантогтох
ШУА-ын ФСЭХ. Социологийн сектор.

Хүн төрөлхтөн оюунжихын хэрээр шашин өөрийн байр сууриа шинжлэх ухаанд аажим аажмаар тавьж өгсөөр байна. Аливаа улс үндэстний хөгжлийн түвшин нь шинжлэх ухаанд суурилсан мэдлэг, батлагдаж нотлогддог үнэнээр хэмжигдэх болов. Энэ үеийн онцлогийг социологийн шинжлэх ухааны аспектаар авч үзвэл секуляризац үйл явц хүчтэй явагдаж байгаа юм. Гэхдээ, “уулын мод урттай, богинотой” гэдгийн адилаар улс орнуудын хөгжил, иргэдийнх нь боловсролын түвшин, соёлын онцлог, ухамсар, нийгэм эдийн засаг, амьдралын хэв маяг, амьдралын философи, оюун санааны онцлог зэрэг олон хүчин зүйлээс хамаарч шашинд итгэх итгэл, сүсэглэх явдал харилцан адилгүй түвшинд илэрдэг аж. Үүний тод жишээг бид “2012.12.21”-ны өдөр буюу Маяачуудын цаг тоолол¹⁶⁹ дуусч, нарны шинэ эринд шилжинэ гэсэн мэдээлэл, түүний нийгэмд үзүүлсэн нөлөөллөөс харж болно.

Үйл явцын өрнөл, гарсан үр дүнг нь үндэслэлтэй тайлбарлах үүднээс нийгэм-сэтгэл зүйн болон социологийн онолуудыг зэрэгцүүлэн авч үзэж болох юм. *Нийгэм-сэтгэл зүйн* талаас З.Фрейдийн тодорхойлсончлон “Олон түмэн удирдагчаа дагахаа больж (*Тухайлбал, МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж эл өдөр ямар нэг гэнэтийн үзэгдэл болохгүй гэж мэдэгдэл хийж байсан*¹⁷⁰), хувь хувиа бодсон психологийн төлөв байдал” буюу паник, зарим талаар хаос¹⁷¹ төлөв байдалд орж ил бус айдас, түгшүүрт автаж байлаа. Сэтгэл зүйн энэхүү төлөв байдлын шалтгааныг “Хүмүүсийн мэгдэж сандрах нь таагүй нөхцөлд ер бусын хүчтэй цочроогч, эсвэл байнгын түгшүүрээс үүдэн бий болдог байна”¹⁷² гэсэн хандлагаар тайлбарлаж болох бөгөөд *үл тулгарах аюулыг* бодитой хэрэгжих үйл явц мэт тайлбарлаж байсан нь олонхийн хувьд илэрхий бус боловч таагүй уур амьсгал бүрэлдэхэд нөлөөлсөн. Гэхдээ ийм түгшүүр зөвхөн Монгол улсаар хязгаарлагдаагүй бөгөөд тухайлбал, “... ОХУ-ын нийслэл Москва хотоос 60 км газарт 60000 хүн багтах байгууламж, Швейцарьт элитүүд хоргодох газар барьж байгаа тухай, Бразилийн Рио Де Жанейро хотын захирагч хүн амаа энэ болзошгүй гамшгаас хамгаалах тухай уриалга гаргасан”¹⁷³ бол өөр нэг мэдээлэлд “... 2012 оны арван нэгдүгээр сараас хойш Москва хотод лаа болон шүдэнз, дулаан хувцас, байшингийн дулаалга, цасны хучлага, ус нэвтэрдэггүй хувцас, хэрэглэлийг худалдан авах хүмүүсийн тоо олширсон тухай Итар-Тасс мэдээлжээ. Мөн ОХУ-ын онцгой байдлын газрынхан 2012 оны арван хоёрдугаар сард өндөржүүлсэн бэлэн байдал зарлан, хүн хүчнийхээ тоог нэмсэн байна.

Харин Хятад улсад энэ байдалтай албадлагын аргаар тэмцэж байв. Мөхлийн өдрийн тухай дурьдсан ном, сонин, сэтгүүл, кино, зурагт хуудас, хувцас зэргийг хурааж, энэ талаар цуурхал дэгдээсэн 200 гаруй хүнийг албадан саатуулсан гэдгийг “Синхуа” агентлаг мэдээлсэн юм.

Өмнөд Америкийн Бразилд ч мөхлийн өдөрт бэлтгэх ажил 2012 оны аравдугаар сараас эхэлсэн. Сао Франчиско де Паула, Рио Гранде до Сул зэрэг хотод ус болон хүнсний бүтээгдэхүүний эрэлт өмнөх жилүүдийнхээс ихэссэн бөгөөд Рио Гранде до Сул мужид *хүнсний бүтээгдэхүүний хомсдол үүссэн* байна. Мөн Соржиньёо хотын Мато Гроссо до Сул дүүргийн томоохон зочид буудлууд арван хоёрдугаар сарын 21-нээс хойшхи бүх захиалгаа цуцалжээ. Эдгээрээс хамгийн аймшигтай үйл явдал Тересина хотод аравдугаар сарын 11-ний өдөр гарчээ. Шашны томоохон байгууллагын мөргөл болж байх үеэр *Гэгээн эх дагины сүмийн оройгоос 80 гаруй хүн үсэрч амиа хорлох гэжээ*. Үүнийг тус

169 <http://theyugas.com/2012-the-mayan-calendar-and-the-yugas/>

170 <http://www.24tsag.mn/content/24359.shtml> // Ц.Элбэгдорж: “21-ний цуурхалыг далимдуулж хууль зөрчихгүй байхыг анхааруулья”

171 Д.Оюунцэцэг. Олон нийтийн санаа бодлын социологи. УБ., 2000. 85-86 дахь тал.

172 Л.Уранцэцэг, М.Дэлгэржав. Нийгмийн сэтгэл судлал. УБ., 2012. 68 дахь тал.

173 <http://www.medee.mn/main.php?eid=21943>

хотын нэгэн иргэн фейсбүүк хуудсандаа бичжээ.”¹⁷⁴ гэсэн баримтууд олон нийтийн сэтгэл санаа тогтворгүйтэхэд багагүй нөлөөлж байсан юм.

Социал үйл явц болохынх нь хувьд Лебоны “Халдварын онол”, Г.Тардын “Дууриах” онолын хандлагад тулгуурлан тайлбарлаж болох юм. Нийгэм хаос төлөв байдалд орсон үед Лебоны “Олон түмэн ба бөөгнөрсөн хүмүүс нь ерөнхийдөө ийм хаос төлөв байдалтай байдаг учраас зохион байгуулалт, удирдлагыг зөнгөөрөө хүлээн зөвшөөрч, түүнд татагдаж байдаг.”¹⁷⁵ гэж хэлсэнчлэн “2012.12.21” болохын өмнөх өдрүүдэд ил бус боловч *сөрөг ухуулагчдын ятгалга, нөлөөнд автаж битүүхэн боловч айдаст автах хандлага ажиглагдаж* байлаа. Харин С.Сигеле Г.Тардын дууриах онолын учир шалтгааныг “... ятгах үнэмшүүлгээ нэг хувь хүнд, эсхүл хэд хэдэн хүнд, эсхүл бүр маш олон хүнд ч нөлөөлж болно; энэ ятгах нөлөө жинхэнэ халдварт тахлын адилаар нийгэмд гүн нөлөөлдөг, гэхдээ зарим нэг нь эл нөлөөлөлд өртдөггүй, зарим нь хөнгөн өртдөг, зарим нь маш хүчтэй урхилагдан автдаг юм. Энэхүү сүүлийнх нь тохиолдолд гэвэл, ятгах нөлөөний буй болгосон үзэгдэл нь, ямар ч хачин, ямар ч аюумшигтай байлаа гэсэн сэтгэцийн аливаа үзэгдлийн үндсэн шалтгаан болсон, ерөөсөө л ятгах нөлөөнөөс үүсэх ерийн нэг, гарцаагүй үзэгдлийн хамгийн дээд шат, илүү хурц илрэл юм. Уг үзэгдлийн эрчим идэвхи нь л янз янз байж болно, харин уг чанар нь нэг ажгуу.”¹⁷⁶ хэмээн тайлбарласан. Үүнтэй адилаар “2012.12.21”-нд олон нийт албан ёсны мэдээллээс илүүтэй мэргэн түргэн, төлөгч, бөө гэх, зарим талаар олны танил хүмүүс ч энэ өдрийн талаар таамаглал дэвшүүлж, олон нийтийг таагүй байдалд оруулж байсан юм.

Тоглогчид

Социологич Жон Лофландын хамтын зан төлөвт зуршмал байдаг айх, дайсагнах, баярлах¹⁷⁷ гэсэн сэтгэлийн хөдөлгөөний гурван үндсэн маягаас “2012.12.21”-ний өдөр болох үед айх, болгоомжлох сэтгэл зүй давамгайлж байлаа. Учир зүйг хөөн үзвэл, ийм зүйл яагаад бий болдог уг шалтгааны талаар доктор Т.Содномдаргиа “... мухар сүсэглэлд автагдаж буй өөр нэг шалтгаан бол тэдгээр хүмүүсийн боловсрол, соёлжилтын түвшин доогуур байгаа явдал юм.”¹⁷⁸ хэмээн дүгнэсэн байдаг бөгөөд сэтгэл зүйн таагүй хэв маяг бүрэлдэхэд нийгэм-эдийн засгийн хөгжил, амьжиргааны түвшин доогуур, иргэдийн боловсрол нимгэн, аливааг баримтаар бус сэтгэл хөдлөлд тулгуурлан хүлээж авдаг хандлага зэрэг нийгэм-соёлын хүчин зүйлс нөлөөлдөг аж. Энэхүү нөхцөл байдал нь аливаа суртал, ухуулга газар авах, хүрээгээ тэлэх таатай хөрс болж буй учир сүсгээр дамжуулж нийгэмд нөлөөлөх гэсэн оролдлого их гарч байгаа юм.

Үйл явцын өрнөлийг эргэн санавал дурдан буй өдөр ямар нэг зүйл болохгүй талаар олон улсад НАСА, Монголд онцгой байдлын газар, Одон орон, геофизикийн судалгааны төв, Ус цаг уур, орчны хүрээлэн зэрэг судалгаа, шинжилгээний байгууллагууд олон дахин мэдээлж байсан ч “дэлхий гадаргаа шилгээж галав юүлнэ, их хүйтрэл болно, газар хөдлөлт болно, түнэр харанхуй болно, солир дэлхийг мөргөнө, Нибуру гараг г.м” хуурмаг мэдээлэл ихээр цацагдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч идэвхитэй нөлөө үзүүлж байв.

Хуурмаг мэдээлэлд, ялангуяа шашны өнгө аястай, зарим талаар “... амин хувиа бодогч, завшигч этгээдүүд сүсэгтний дүр гарган сүсэгтнүүдийн дунд орж өөрийгөө *ид шидтэн, “бариац, илээч”* гэх мэтээр сурталчлан дүвчигнэх явдал хааяа тохиолддог.”¹⁷⁹ гэсэнчлэн нэр хүнд, ашиг хонжоо хайгчид идэвхитэй тоглолт үзүүлж байсан. Энгийнээр хэлбэл, эерэг (*тайвшруулах, ойлгуулах*) болон сөрөг (*өөрийгөө сурталчилах, бусдаар хүрээлүүлэх, дагагчидтай болох г.м хувийн шалтгаанаар О.Б*) талын ухуулагчид эл өдөр болохтой зэрэгцэн идэвхитэй тайлбаруудыг хийж байлаа.

174 <http://www.topmedee.mn/newsprint/13211>

175 Д.Оюунцэцэг. Олон нийтийн санаа бодлын социологи. УБ., 2000. 89 дэх тал.

176 Сципион Сегеле. Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг. Софи., 2002. 47 дахь тал.

177 <http://tsogtbaatar.blogspot.com/2008/07/blog-post.html>

178 Т.Содномдаргиа. Шашингүйн үзлийн товч толь. Улсын хэвлэлийн газар. УБ., 1985. 61 дэх тал.

179 Т.Содномдаргиа. Шашингүйн үзлийн товч толь. Улсын хэвлэлийн газар. УБ., 1985. 61 дэх тал.


Хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд “2012.12.21”-ны талаарх нийгмийн хандлагыг цаг алдалгүй дамжуулж байсны зэрэгцээ эл өдөр юу болох бол гэсэн битүүхэн “ТААМАГЛАЛ”, хэлэлцүүлэг өрнүүлэх хэмжээний “СЭДЭВ”-ийг олон нийтийн дунд үлдээж байсан. Зарим талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон нийтийг татах зорилгоор эл сэдвийг дэврээж байсныг үгүйсгэхгүй ч энэхүү асуудал олон нийтийн дунд тархахад гол үүрэг гүйцэтгэсэн юм. Үр дүнг нь энэхүү хуурмаг мэдээллийн тархацаас харж болно.

Социаль үр нөлөө

Өнөө үед шинжлэх ухаан урьд хожид байгаагүй өндөр түвшинд хөгжсөн боловч олон нийтийн дунд ер бусын хүчинд итгэх итгэл, батлагдаагүй зүйлд сүсэглэх, энэ талын мэдээллийг хөөргөх хандлага ажиглагдаж байсан бөгөөд нийгэмд энэ талын мэдээллийг хэт түргэн шингээн авч байв. Шинжлэх ухааны хувьд батлагдсан боловч¹⁸⁰ ер бусын хүчин зүйлээр дамжуулж олон нийтийг төөрөгдүүлж байсны дээр янз бүрийн оролдлогын үр дүнд нэг хэсэг нь өөрсдийн нэр сүрийг өсгөх, нөгөө хэсэг нь олонд хүлээн зөвшөөрөгдөхийг эрмэлзэж байв. Мөн олон нийтийг өөрийн арга залинд итгүүлэх, улмаар санхүүгийн боломжоо дээшлүүлэх гэсэн зорилготой үйлдэл хийж байсныг үгүйсгэх аргагүй. Энэ мэт үйлдлийн цаад үр дагавар нь олон нийтийн дунд эмх замбараагүй байдал үүсгэх, нийгмийг аноми төлөвт оруулах сөрөг үр дагавартай байдаг. Энэ нь түүхэн дэх олон баримтаар нотлогдсоны зэрэгцээ “2012.12.21” болохтой холбоотой Монголд болон гадаадын улс орнуудад ямар үйл явдал өрнөснөөс харж болох юм. Иймийн учир эл өдрийн талаарх худал мэдээлэл, түүний цар хүрээ, үр дүн нь нийгэмд хэрхэн тусаж байсныг тодруулах зорилготой уг бичил санал асуулгыг явуулсан юм.

Санал асуулгад 425 респондент хамрагдсан бөгөөд нас, хүйсийн хувьд Улаанбаатарын оршин суугчдыг бүтцийн хувьд төлөөлж чадаж байна. Мөн боловсрол, ажил мэргэжил, өрхийн орлого, шашин шүтлэгийн онцлогийг судалгааны асуулгад тусган хоёрдогч боловсруулалт хийн тодорхой таамаглалуудыг шалгасан боловч доор үзүүлсэн үр дүн бүтцийн хувьд нийгмийн бүлгүүдэд адил, төстэй байдлаар илэрч байсан учир ерөнхий үр дүнг тусгасан болно.


График-1, 2. Санал асуулгад оролцогчдын нас, хүйсийн харьцаа



Судалгааны асуулгад дараах хэдэн асуултын хүрээнд мэдээлэл авч үр дүнг нэгтгэн харахад оролцогчдын 72.8 хувь нь эл өдөр ямар нэг зүйл болохгүй гэж үзэж байсан бол дөрвөн хүний нэг нь ямар нэг зүйл болно гэж (22.4%), 4.8 хувь нь эргэлзсэн байр суурьтай байсан юм.


180 Тайлбар: Ямар нэг гэнэтийн үзэгдэл болохгүй гэдэг нь шинжлэх ухааны судалгааны үр дүнгүүдээр батлагдсан байсан.

График-3. 2012.12.21-ны өдөр ямар нэг үйл явдал болох эсэх талаарх санал асуулгад оролцогчдын байр суурь



Дээрх үр дүнгээс олон нийтийн дунд *илэрхий үгүйсгэсэн байр суурь давамгайлж байсан* ч энэ өдөр юу болох бол, яах бол гэсэн эргэлзээ, түгшүүр өргөн хүрээг хамарч байсан нь дараах үр дүнгээс харагдах бөгөөд үүнд өмнө дурдсанчлан мэргэн төлөгч хүмүүс, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гол үүрэг гүйцэтгэж байв. Онолын хувьд Г.Тардын "... сэтгэл зүйн үүднээс бол, оюуны бүхий л амьдрал нь тархины нэг эсээс нөгөөд дамжигдсан ятгах нөлөөнөөс (үнэмшүүлэлтээс, Б.Даш-Ёндон) өөр зүйл биш; харин үндсэн шалтгааныг нь ухааж төнхөх зорилгоор нийгмийн үүднээс авч үзвэл тэр нь нэгэн бие хүнээс нөгөөд үзүүлэх нөлөөнөөс өөр зүйл биш."¹⁸¹ гэж хэлсэнчлэн айдсаас үүдэлтэй халдвар, сэтгэл зүйн ийм төлөвт орж бусдыг дууриах үйл явц (халдвар болон дууриах үйл явц нь адил зарчмаар, нэгэн зэрэг явагдаж болно О.Б) өргөн хүрээг хамарч, эрчимтэй өрнөдөг болохыг тодорхой ажиглаж болно. "2012.12.21"-ны өдөр юу болох талаар санал асуулгад оролцогчдоос тодруулахад *байгалийн гэнэтийн хүчтэй үзэгдэл болно* гэж 49.6 хувь нь итгэж байсан (их хүйтрэл болно 21.4%, түнэр харанхуй болно 8.2%, газар хөдлөлт болно 4.9%, хүчтэй салхи гарна 4.4% г.м *График-4-д дэлгэрэнгүй үзүүлэв*) бол юу ч болохгүй гэж хариулагсад 32.7 хувийг, эргэлзсэн хэсэг 17.6 хувийг эзлэж байж.

График-4. 2012.12.21-ны өдөр болж болзошгүй үйл явдалын талаарх олон нийтийн таамаглал (Тухайн асуулгад хариулсан 364 респондентын хувьд)



Олон нийтийн субъектив үнэлгээнээс харахад тэдний тал хувь нь дурдан буй өдөр ямар нэгэн гэнэтийн үзэгдэл болно гэж бодож байсан бол объектив үйлдэлээс нь мөн л ийм дүр зураг харагдаж байлаа. Тодруулбал, энэ өдөр болохоос өмнө юу бэлтгэснийг нь асуулгад оролцогчдоос лавлахад тэдний 47.4 хувь нь наад захын хэрэглээний зүйлс (лаа, шүдэнз 19.6 хувь, түлээ, нүүрс 11.2 хувь, хоол, хүнс 12.8 г.м)-ээ нөөцөлж эхэлсэн бол 52.6 хувь нь юу ч бэлдээгүй гэж хариулсан байна. Мөн, эл өдөр архидах¹⁸², зарим бараа бүтээгдэхүүний үнэ болон борлуулалт нэмэгдсэн¹⁸³ зэрэг сөрөг үр дагаврууд илэрч байсныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж байсан.

181 Сципион Сегеле. Хөөрсөн гүмэн ба гэмт хэрэг. Софи., 2002. 44 дэх тал.

182 <http://www.medee.mn/main.php?eid=24667>

183 <http://www.medee.mn/main.php?eid=24532>

График-5. 2012.12.21-ний өдөрөөс эмээж ямар нэг зүйл бэлдсэн эсэх



Бүр График-3-д үзүүлсэн ямар нэг зүйл болохгүй (71.1%) гэж үзэж байсан хүмүүсийн 25.8 хувь нь лаа шүдэнзнээс эхлээд хоол хүнс, түлээ нүүрс бэлтгэж байжээ. Энэ нь хүн амын олонхийн дунд бусдад ил гаргаж чадахгүй ч тодорхой хэмжээний айдас, эргэлзээ байсныг илтгэж байгаа юм. Үүнтэй адил үйл явц АНУ-д тэмдэглэгдсэн байдаг бөгөөд сэтгэл таагүй байдалд орсон хүмүүсийг хэд хэдэн бүлэгт хуваан үздэг аж. Тодруулбал, Г.Уэлсийн “Марсаас халдан ирсэн нь” зохиолоор хийсэн радио жүжгээс үүдсэн олон нийтийн тэвдэлтийг нэгдүгээрт: бага зэргийн айдсыг мэдрэсэн, хоёрдугаарт: айдсын байдалд өөрсдөө бие даан шийдвэр гаргаж чадахгүй, гуравдугаарт: айдсын хүчтэй мэдрэмжид авсан, дөрөвдүгээрт: шууд сандралд орсон¹⁸⁴ дөрвөн бүлгийг тодорхойлж, тус бүрийн шинж байдлыг нь тодорхойлсон байдаг. Үүнтэй төстэй байдлаар тухайн үеийн олон нийтийн төлөв байдлыг тодорхойлохыг эрмэлзлээ.

График-4 болон 5-д үзүүлсэн үр дүнгээс эл өдрийн талаарх хуурмаг мэдээлэл олон нийтийн 50 орчим хувьд нөлөөлсөн мэт дүр зураг харагдаж байгаа ч асуудлыг нарийн шинжлэх явцад энэ нь үүнээс өргөн хүрээг хамарч байжээ. Үр дүнг тодруулбал, олон нийтийн таамаг буюу субъектив хандлага, ямар нэг зүйл бэлдсэн байдал буюу объектив үйлдэл¹⁸⁵ тулгуурлан логик шинжилгээ хийж үр дүнг харвал “2012.12.21” өдөр ямар нэг зүйл болно гэж бүрэн итгэсэн хүмүүс (ямар нэг юм болно хэмээн эмээж юм бэлдсэн) судалгаанд хамрагдсан хүмүүсийн 1/3 хувийг эзлэж байсан бол үл итгэгсэд (үгүйсгэсэн байр суурьтай боловч юм бэлдэх юм уу, ямар нэг зүйл болно гэж итгэсэн) мөн хэмжээний хувийг эзлэж байв. Дөрвөн хүн тутмын нэг нь ямар нэг юм болох вий дээ гэж шаналсан, дотоод айдас тээж явсан бол юу ч болвол болог гэсэн бодолтой хүмүүс 7 хувийг (ямар нэг зүйл болно гэдгийг мэдэхгүй, юу л болвол болог гэж бодсон) эзлэж байжээ.

График-6. Логик шинжилгээний үр дүн



“2012.12.21”-ний өдөр болох үед нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөхүйц үйл явдал болсон бол нийгмийн сэтгэл зүйг бүрэн эзэмдэх, эмх замбараагүй байдлыг тогтоон барих боломжгүй байж гэсэн дүр зураг ажиглагдаж байгаа юм. Учир нь олон нийтийн тал илүү хувь нь (58.3%) хуурмаг мэдээллийн нөлөөнд автсан нь үүнийг бататгаж байна. Мөн энэ талын мэдээлэл өргөн хүрээг

184 Л.Уранцэцэг, М.Дэлгэржав. Нийгмийн сэтгэл судлал. УБ., 2012. 69 дэх тал.

185 С.Цэдэндамба. Монгол улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе)”. УБ., 2003. 57 дахь тал.

хамарснаас үүдэлтэй олон нийтийн дунд энэ өдөрт зориулж ил, далд ямар нэг байдлаар бэлтгэх, олноороо нийлж архидах явдал гарч байсныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цөөнгүй мэдээлж байсан.

Эдгээрээс байр суурь, хандлагад үндэслэн хэлбэл, “2012.12.21”-ний өдөртэй холбоотой айдас бий болоход буюу халдвар тархах, бусдыг даган дууриахад *нэгд*: ухуулагчид, *хоёрт*: мэдээлэл түгээгчид буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэл, *гурв*: хүлээж авах хөрс суурь буюу цаг хугацааны болоод орон зайн хувьд таатай нөхцөл бүрджээ.

Олон нийтийн дунд хуурмаг мэдээлэл тарж, өргөн хүрээг хамарснаас үүдэлтэй нийгмийн сэтгэл зүй тогтворгүйтэх, айдаст автах, эрүүл мэндийн байдал хямрах, янз бүрийн гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрдэх, зарим талаар байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа доголдох, өрхийн төсөвт тооцоологдоогүй, ач холбогдол багатай зарлага нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавартай байдаг аж. Тиймээс мэдээллийн хэрэгсэл болон төрийн удирдах байгууллагын түвшинд хуурмаг мэдээллээс урьдчилан сэргийлэх хэрэгцээ байгааг анхааруулж байгаа юм. Мөн хуурмаг мэдээллээс үүдэлтэй үүсч болох эрсдэлээс хэрхэн сэргийлэх вэ гэх мэт нөхцөл байдлыг олон талаас нь тооцоолж ажиллах шаардлагатайг давхар харуулсан үйл явдал болсон.

Ашигласан материал

1. БНМАУ Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. Шинжлэх ухааны шашингүйн үзлийн үндэс. УБ., 1985.
2. Д.Цэндээ. Хөдөлмөрчдийн шашингүйн хүмүүжил ба бурхангүйчүүдийн эвлэл. УБ., 1975.
3. С.Цэдэндамба. Монгол улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе)”. УБ., 2003.
4. Д.Оюунцэцэг. Олон нийтийн санаа бодлын социологи. УБ., 2000.
5. Л.Уранцэцэг, М.Дэлгэржав. Нийгмийн сэтгэл судлал. УБ., 2012.
6. Н.Смелзер. Социологи. Ред: проф Ү.Нямдорж. УБ., 2001.
7. Т.Содномдаргиа. Шашингүйн үзлийн зарим асуудал. Улсын хэвлэлийн газар. УБ., 1987.
8. Т.Содномдаргиа. Шашингүйн үзлийн товч толь. Улсын хэвлэлийн газар. УБ., 1985.
9. Сципион Сигеле. Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг. Софи., 2002. Шинжлэх ухаан шашингүйн үзлийн үндэс. Улсын хэвлэлийн газар. УБ., 1984.
10. ШУА-ийн ШСТ, УБИС-ийн НУТ. “Шашин судлал” эхлэн сурах бичиг. Ред: док (Ph.D), проф Д.Дагвадорж. УБ., 2001.
11. ШУА-ийн ФСЭХ. Хөдөлмөрчдийн шашингүйн хүмүүжлийн өнөөгийн асуудал. УБ., 1985.
12. <http://www.medee.mn>
13. <http://www.topmedee.mn>
14. <http://theyugas.com>
15. <http://tsogtbaatar.blogspot.com>